БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Г. ЧИНБАТ
20...24... оны ...04... дугаар сарын ...30... өдөр

УЛААН ШАЛЫН ХООЛОЙ, ЗАРМАНГИЙН ГОВЬД НАРНЫ ӨРГҮҮРТ ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.04.30 Алтай хот

Д/д	Хийгдэх ажлын нэр	Бүрдүүлэх баримт, гарах үр дүн
1	Улаан шалын хоолой, зармангийн говьд нарны өргүүрт инженерийн хийцтэй худаг гаргах ажлын даалгавар	Заагдсан 2 байршилд зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нарны өргүүртэй инженерийн хийцтэй худаг гаргах, 1 байршилд ногоон байгууламжийн усалгааг шийдвэрлэх зорилгоор 1 худаг гаргах ажлын зардлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал шийдвэрийн дагуу төсвийг /төсвийн программаар/ боловсруулна.
2	Байршил	-Цогт сумын нутаг, Төгрөг багийн "Хаяагийн хойт цагаан"-д (N45°20'29.9" E97°59'59,3") - Баянтоорой багийн Хайчин (N45°12'3.40" E96°14'12,41") усны хайгуул хийгдсэн цэгт өрөмдлөг хийж, нарны өргүүрт худаг болгон тоноглох -Чандмань сумын нутаг Талын шанд багийн Хургалжийн тал (N45°20'29.9" E97°59'59.3") усны хайгуул хийж худгийн цооног өрөмдөж, худаг тохижуулах /өгөгдсөн газарзүйн байршлуудаас 10км-ээс ихгүй байршилд байж болно/
3	Захиалагч байгууллага	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төсөл
4	Тоо хэмжээ, тавигдах шаардлага	-Заагдсан байршлуудад усны хайгуул хийж гүн өрмийн, инженерийн хийцтэй худаг гаргасан байна -Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих ерөнхий шаардлага MNS6088:2010 стандартын дагуу худгийн цооног гаргах, тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах ажлыг зохион байгуулж техникийн тодорхойлолтод заагдсан үзүүлэлтийн дагуу захиалагч болон ашиглагчийг байлцуулан угсарч, суурилуулан туршиж, ашиглалтын хэвийн ажиллагаанд бэлэн болгож захиалагчид хүлээлгэн өгнө. -Худгуудын усны ундрага, статик, динамик түвшинг хэмжиж тооцсоны үндсэн дээр худгийн тоног төхөөрөмжийг сонгосон байна.

		-Инженерийн хийцтэй уст цэгийг шинээр гаргаж, нарны өргүүрт болгон тоноглож хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэн худгийн пасспорт болон ашиглах зааврын хамт бэлтгэж өгнө.
5	Ажил гүйцэтгэх хугацаа	2024 оны 09 сарын 25-ны дотор
6	Багц ажлын үнэ /захиалагчийн хяналтын зардал, тээврийн зардал бусад зардалууд багтсан байна/	-Аймгаас-40.000.000 (Дөчин сая) -Цогт сум-30.000.000 (гучин сая), Чандмань-15.000.000 (арван таван сая) -Төсөл-39.861.432 (Гучин есөн сая найман зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун гучин хоёр) 124,861,432 (нэг зуун хорин дөрвөн сая найман зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөг. /тээвэр шатахуун, ажлын хөлс, бусад зардал багтсан болно/
7	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	• Усны мэргэжлийн байгууллагын эрхтэй байх • Ижил төстэй ажил хийж гүйцэтгэж байсан туршлагатай байх • Шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхтай байх

ЗЭРЛЭГ АМЬТНЫ УСАН ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН УСАЛГААНЫ ЗОРИЛГООР УЛААН ШАЛЫН ХООЛОЙ БОЛОН ЗАРМАНГИЙН ГОВЬД НАРНЫ ӨРГҮҮРТ ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДАГ ГАРГАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. НЭР ТӨРӨЛ: НАРНЫ ӨРГҮҮРТ ХУДГИЙН ЦООНОГ ӨРӨМДӨХ,

Худгийн цооног гаргах, хөв байгуулах:

1.1. Усны гидрогеологийн судалгааны ажлыг өгөгдсөн цэгүүдээс (N45°20'29.9" E97°59'59.3") , (N45°20'29.9" E97°59'59,3") , (N45°12'3.40" E96°14'12,41") 10км-ийн радиуст хийж, уст цэгийг тогтоосны дараа өрөмдлөг хийнэ. Хуурай өрөмдсөн тохиолдолд эрсдлийг гүйцэтгэгч хариуцна.

1.2.Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих ерөнхий шаардлага MNS6088:2010 стандартын дагуу худгийн тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах ажлыг зохион байгуулна.

1.3.Монгол Улсын Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргаж, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэх журам"-ыг мөрдөнө.

1.4.Ашиглалтын цооногийг шавхаж, усны ундрага, статик, динамик түвшинг хэмжиж тогтоосон тухай акт үйлдэнэ.

1.5.Ашиглалтын цооногийн ундрага 0,5л/сек-ээс багагүй байх

1.6.Суултын хоолой 159мм-с багагүй байх ба ган эсвэл хуванцар (ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн байх ба хүйтний улиралд тэсвэртэй) байж болно.

1.7.Шүүрийн хоолой нь ган эсвэл хуванцар (ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн байх ба хүйтний улиралд тэсвэртэй) байх

1.8.Ус өргөх хоолой 32мм-с багагүй байх ба ган эсвэл хуванцар (ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн байх ба хүйтний улиралд тэсвэртэй) байж болно.

1.9.Худгийн цооногоос 50м зайд 3х2м талбайтай, 40см-с багагүй гүнтэй ус хуримтлуулах хэсэгтэй байна. Ус хуримтлуулах хэсэг нь ус нэвчихгүй байх ба илүүдэл ус гадагш урсахаар хийгдсэн байна.

1.10.Худгийн усны шахуурга, нарны цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, цагийн тохиргооны төхөөрөмж, холбогч хэрэгсэл, дагалдах эд зүйлсийг техникийн тодорхойлолтод зааснаар иж бүрэн суурилуулсан байна.

1.11.Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хийц болон механик ямар нэгэн гэмтэл согогүй, чанартай бат бөх, чанарын баталгаат хугацаа 2 жил ба түүнээс дээш байна.

2. НЭР ТӨРӨЛ: НАРНЫ ӨРГҮҮРТ ХУДГИЙН ШАХУУРГА

2.1.	Үзүүлэлт	Нарны цацрагийн хэмжээ 1000-1500 Вт цаг/м^2 байхад Н=50м гүнээс ус татах шахуургын /насос/ бүтээмж 3.0 – 5.0 м^3/цаг /Напор Н60-70м/-ээс багагүй байна.
		Шахуургыг худагт зүүх хамгаалалттай тросс, гүний цахилгаан шахуургыг удирдах самбартай холбох усны зориулалтын кабельтай байна.

		Шахуурга нь тогтмол гүйдлийн цахилгаанаар ажиллах боломжтой байна.
2.2.	Чанар	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хийц болон механик ямар нэгэн гэмтэл согогүй, чанартай бат бөх, чанарын баталгаат хугацаа 2 жил ба түүнээс дээш байна.
2.3.	Тоо ширхэг	1 ширхэг
2.4.	Тендерийн материалын хамт фото зураг, гарал үүслийн гэрчилгээ, үйлдвэрийн техникийн үзүүлэлтийг ирүүлнэ.	

3. НЭР ТӨРӨЛ: НАРНЫ ЗАЙН ДЭЛГЭЦ

3.1.	Үзүүлэлт /Усны ундаргаас хамаарч, тоног төхөөрөмжийн хүчин чадал өөрчлөгдөж болох бөгөөд хамгийн багаад дараах үзүүлэлтийг хангасан байна/	Нарны цахилгаан үүсгүүр нь ISO-9001 стандартын шаардлагыг хангасан байна.
		Нарны цахилгаан үүсгүүрийн иж бүрдэлд нарны цахилгаан үүсгүүр, суурийн хамт байна.
		Нарны цахилгаан үүсгүүрийн нийлбэр чадал нь 360 Вт-аас дээш байна.
		Нарны цахилгаан үүсгүүрийн хэвийн ажиллах нарны цацрагийн хэмжээ 1000 Вт цаг/м^2-аас багагүй байна.
		Ус өргүүр ажиллаж эхлэх нарны цацрагийн хэмжээ нь 600 Вт цаг/м^2-аас багагүй байна.
		Нарны цахилгаан үүсгүүр нь цэнэг хураагууртай байна
3.2.	Суурилуулалт	Нарны цахилгаан үүсгүүр нь 45 хэм налуу төмөр сууринд бэхлэгдэх ба суурийг бетондож суурилуулна. Суурь нь нарны гийгүүлэлтийг бүрэн авахаар байх.
		Нарны цахилгаан үүсгүүрээс гарах цахилгааны утсыг худгийн цооногт оруулахдаа газрын гадаргаас доош 0.5 метр гүнд ухаж байрлуулна. Нарны зайн дэлгэцийг мал, амьтнаас хашаагаар тусгаарлаж хамгаалсан байх бөгөөд хашааны хэмжээ 1,5 метр өндөр, 3 х 4 хэмжээтэй бат бөх төмөр хийцтэй байна.
3.3.	Чанар	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хийц болон механик ямар нэгэн гэмтэл согогүй, чанартай бат бөх, чанарын баталгаат хугацаа 2 жил ба түүнээс дээш байна.
3.4.	Тоо ширхэг	Иж бүрдэл

3.5.	Тендерийн материалын хамт фото зураг, гарал үүслийн гэрчилгээ, үйлдвэрийн техникийн үзүүлэлтийг ирүүлнэ.

4. НЭР ТӨРӨЛ: НАРНЫ ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРЭЭР АЖИЛЛАДАГ ГҮНИЙ ЦАХИЛГААН ШАХУУРГА УДИРДАХ САМБАР

4.1.	Үзүүлэлт	Удирдах самбарыг нарны цахилгаан үүсгүүртэй холбох кабель, шахуургыг удирдах самбартай холбох усны зориулалтын кабельтай зэрэг байна.
		Цагийн тохируулгатай байна.
4.2.	Чанар	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хийц болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, чанартай бат бөх, чанарын баталгаат хугацаа 2 жил ба түүнээс дээш байна.
4.3.	Тоо ширхэг	Иж бүрдэл
4.4.	Тендерийн материалын хамт фото зураг, гарал үүслийн гэрчилгээ, үйлдвэрийн техникийн үзүүлэлтийг ирүүлнэ.	

ХЯНАСАН:

ХБТХОХ-ИЙН ДАРГА Л. ХАШ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ЦЭРЭНБАЛ